



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 22

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14-р тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 2.9 дах заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймгийн Зүүнбүрэн сумын Соёлын төвийн эрхлэгч Д.Лхамгарьд, иргэн С.Эрдэнэчимэг нарын сумын ЗДТГ-ын мэргэжилтэн С.Цэлмэгтэй холбоотой гомдол, мөн сумын иргэн Г.Уртнасан, Б.Уянга нарын соёлын төвийн сул орон тооны сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар Төрийн албаны салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батсайхан - Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн

Гишүүн:

Д.Энхсайхан -Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн

Б.Дарихжав -Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Г.Эрдэнэчимэг -Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн

2. Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж дүгнэлт санал боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар оруулж хугацаанд нь шийдвэрлэхийг ажлын хэсгийн ахлагч /Ж.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА